

## Чанарын судалгааны NVivo програмын эрэлт хэрэгцээ

Т.Батболд\*

МУБИС, Боловсрол судлалын сургууль, Судалгааны арга зүйн тэнхим

### Хураангуй

Энэхүү судалгаагаар Монгол улсын боловсролын салбарт сүүлийн жилүүдэд шинээр хэрэгжиж буй чанарын мэдээллийн шинжилгээний NVivo програмын эрэлт хэрэгцээг тодорхойлохыг зорьсон. Монгол улсад дийлэнх судлаачид тоон мэдээллийн шинжилгээний SPSS, Stata, Access програмуудыг магадгүй сайн ашигладаг бол цөөн тооны хүмүүс чанарын мэдээллийн шинжилгээний програм дээр ажиллаж чадна. Тийм учраас энэ сэдвийг сонгосон бөгөөд зарим сонирхолтой үр дүнгүүд гарна гэж таамагласан. Монгол Улсын Боловсролын Их Сургууль (МУБИС)-д сурч буй бакалаврын 207, магистрын ангийн 27, докторын ангийн 27 буюу нийт 260 суралцагчийг түүвэрлэн авч судалгаанд хамруулсан. Судалгааны аргазүй нь тоон мэдээлэлд шинжилгээ хийсэн. Тус судалгааны үр дүнд суралцагчдын 90%-95% нь NVivo програмыг ашиглахыг хүссэн бөгөөд энэ нь эрэлт хэрэгцээ их байгааг харуулж байна. Гэвч нэг сонирхолтой үр дүн ажиглагдсан нь бакалаврын оюутнууд гол төлөв NVivo програмын эрэлт хэрэгцээний талаарх асуултад “үгүй”, “мэдэхгүй” гэж хариулсан. Мөн судалгаанд хамрагдагчдын 60%-70% нь судалгааны мэдээлэл цуглуулахдаа ярилцлага, ажиглалт, агуулгын шинжилгээний аргуудыг ашигладаг боловч тэд ямар нэгэн чанарын судалгааны ашиглахгүй байгаа нь судалгааны үр дүнг бүрэн дүүрэн боловсруулж чаддаггүй байна.

### Түлхүүр үг

Хэрэглээ, боловсролын салбар, чанарын мэдээлэл, суралцагч, сургалт, МУБИС

### Удиртгал

Судалгаа шинжилгээний ажил бүх түвшинд хурдацтай хөгжиж буй өнөө үед судлаачид программ хангамжийн тусламжтайгаар цуглуулсан баримт, мэдээлэлд дүн шинжилгээ хийхийг илүүд үзэж байна. Тухайлбал, боловсролын салбарт тоон мэдээлэлд шинжилгээ хийх SPSS програмыг харьцангуй өргөн хүрээнд ашиглаж байгаа хэдий ч чанарын мэдээлэлд дүн шинжилгээ хийх ямар нэгэн программ хангамжийг төдийлөн ашиглахгүй байна. Иймээс энэхүү судалгаагаар боловсролын салбар түүний дотор МУБИС-ийн бүх түвшний сургалтад чанарын мэдээлэлд шинжилгээ хийх NVivo программын эрэлт хэрэгцээ ямар байгааг тодорхойлохыг зорьсон болно.

Дийлэнх чанарын судлаачид нийгмийн янз бүрийн үзэгдлийг тайлбарлах, тодорхойлох, үнэлэх сонирхолтой байдаг. Тэд боловсрол, эрүүл мэнд, бизнес, улс төр зэрэг өргөн хүрээний салбарт ажилладаг бөгөөд өгүүлэл, вэб хуудас, тэмдэглэл, ажиглалт, ярилцлага, баримт зэргээс мэдээллийг цуглуулж шинжилгээ хийдэг. Энэ тохиолдолд чанарын судалгааны NVivo програмыг ашиглаж төрөл бүрийн чанарын мэдээллийг эмхэлж цэгцлэх, кодлох, шинжилгээ хийх, хуваарилах зэргийг илүү хялбар болгодог (QSR олон улсын компани<sup>1</sup>,

2016, х.4). Судлаачид ихэвчлэн судалгааны судлах асуултад тохируулан чанарын судалгааны арга зүйг сонгодог. Жишээлбэл, нийгмийн судлаачид шинэ ухагдахууныг хөгжүүлэх, онол боловсруулах судалгааны таамаглал дэвшүүлэхийг зорьдог байна.

NVivo программ нь үг, өгүүлбэр, зураг, аудио, видео, хөдөлгөөнт контент зэрэг өргөн цар хүрээний өгөгдлийг боловсруулах, шинжлэхэд судлаачдад тусалдаг (Бинт<sup>2</sup>, Аллан<sup>3</sup>, 2015, х.48). Чанарын мэдээллийг боловсруулах, шинжлэхийн тулд судлаачийн мэдлэг, туршлага зайлшгүй шаардлагатай, тухайлбал, нэг үзэл санаанд тулгуурлан мэдээлэл цуглуулдаг судлаачид тэр чиглэлээр судалгаа хийх нь илүү тохиромжтой (Нориах<sup>4</sup>, Абу<sup>5</sup>, 2012, х.94). Чанарын мэдээллийн шинжилгээ нь тодорхой өгөгдлийг боловсруулах үйл явцад ашиглагддаг. Энэ үйл явцад текстийн хэсгүүд нь юун түрүүнд бүрэн утга санааг илэрхийлсэн эх сурвалжаас бүрдэж, дараа нь бодит баримт дээр суурилсан утга болон илүү нарийвчилсан мэдээлэл дээр ажиллана (Жонис<sup>6</sup>, 2007, х.64).

2 Bengt

3 Allan

4 Noriah

5 Abu

6 Jones

\* ✉ [tbatbold@msue.edu.mn](mailto:tbatbold@msue.edu.mn)

1 QSR International Pty Ltd

Манай улсад чанарын судлаачдын тоо сүүлийн жилүүдэд боловсролын бодлого болон нийгмийн хөгжлийн үр дүнд хурдацтай өсөн нэмэгдэж байна. Гэсэн хэдий ч тэд баримт мэдээллийг судалж, шинжлэхийн тулд ямар нэгэн чанарын судалгааны программ хангамж ашиглах нь цөөн байна. Иймээс тус судалгааг хийх зайлшгүй шаардлагатай бөгөөд ялангуяа МУБИС-д NVivo программыг нэвтрүүлэх эрэлт хэрэгцээний талаар судалсан болно. Энэ нь магадгүй ирээдүйд олон залуу судлаачдын судалгааны ажилд үнэтэй хөрөнгө оруулалт болох, тэдний судалгааны ажлын сонирхлыг нэмэгдүүлэх, ажлыг нь хөнгөвчлөх боломж бүрдэнэ.

### Мэдээллийн эх сурвалж ба судалгааны арга

МУБИС дахь NVivo программын эрэлт хэрэгцээг мэдээлэл цуглуулах аргачлалын дагуу асуулга болон баримтын шинжилгээний аргыг ашиглаж судалсан (Батболд нар, 2017, х.119). МУБИС-ийн бакалавр, магистрантур, докторантурт 16 ялгаатай мэргэжлээр суралцаж буй нийт 260 суралцагчаас асуулгын аргаар мэдээлэл цуглуулсан. Асуулга нь тийм, үгүй, олон сонголттой гэсэн хэлбэртэй бөгөөд ерөнхий мэдээлэл болон үндсэн асуулт гэсэн хоёр хэлбэртэй. Харин зарим тоон мэдээллийг макро түвшний эмхэтгэл (Статистикийн эмхэтгэл, 2016, х.168) болон 2016-2017 оны хичээлийн жилийн боловсролын салбарын тайлан (Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын яам, 2017, х.54)-аас авсан болно.

Судалгааны үр дүнг SPSS.22 программ ашиглан боловсруулж тодорхойлох статистик, давтамж, хүснэгт, стандарт хазайлт болон статистикийн ач холбогдлыг тооцсон (Батболд нар, 2018, х.204). Мөн баримтууд дээр ажиллахын тулд агуулгын шинжилгээний аргыг ашигласан.

### Судалгааны үр дүн

#### 1. Судалгаанд оролцогчдын ерөнхий мэдээлэл

2016-2017 оны хичээлийн жилд дотоодын их, дээд сургууль болон коллежид бүх мэргэжлээр нийт 157138 оюутан суралцаж байгаагаас боловсролын салбарт багш, боловсрол судлал, сэтгэл судлалын чиглэлээр 22006 оюутан суралцаж байна (Үндэсний статистикийн хороо, 2016, х.149). 2017 онд МУБИС-д нийт 13131 оюутан суралцаж байна (БСШУС-ын яам, 2017, х.6).

Тус судалгаанд асуулгын аргаар нийт 260 суралцагч хамрагдсан бөгөөд тэдгээрийн ерөнхий

мэдээллийн зарим үр дүнг авч үзье.

#### Хүснэгт 1

##### Тодорхойлох статистик

	N	Minimum	Maximum	Mean	Std. Deviation
Суралцагчдын нас	254	18	45	21.96	4.93
Хүчингүй N	6				

Дээрх хүснэгт нь суралцагчдын насны тодорхойлох статистикийг үзүүлж байна, тухайлбал, дундаж нас 22 бөгөөд стандарт хазайлт нь 4.93 байгаа нь хэвийн түвшинд гарсан.

#### Хүснэгт 2

##### Суралцагчдын курс

	Давтамж	Хувь	Хүчинтэй хувь
Бакалавр	206	79.2	79.2%
Магистрантур	27	10.4	10.4%
Докторантур	27	10.4	10.4%
Нийт	260	100.0	100 %

Бакалаврын 206 оюутан буюу ойролцоогоор 80 хувь, магистрантур болон докторантурт 54 суралцагч буюу ойролцоогоор 20 хувь, хүчинтэй хувь нь 100 (Хүснэгт 2).

#### 2. МУБИС дахь NVivo программын эрэлт хэрэгцээ

Тус судалгааны объектыг боловсролын салбарын төлөөлөл болох МУБИС-ийг жишээ болгон сонгож авсан, учир нь багш мэргэжил болон боловсрол судлалаар ойролцоогоор 22 мянган оюутан суралцаж байна. Тиймээс боловсролын салбарыг МУБИС нь төлөөлөх чадвартай гэж үзсэн.

Судалгаанд оролцогчдын өгсөн хариултуудаас зарим сонирхолтой онцлог үр дүнгүүдийг дараах байдлаар авч үзье.

#### Хүснэгт 3

##### Чанарын мэдээллийн шинжилгээний NVivo программын эрэлт хэрэгцээ байгаа эсэх

	Тийм	Үгүй	Мэдэхгүй	Нийт
Бакалавр	178	14	14	206
Магистрантур	26	0	1	27
Докторантур	26	0	1	27
Нийт	230	14	16	260

Нийт судалгаанд оролцогчдын ойролцоогоор 88% нь тус программын эрэлт хэрэгцээ байна

гэж хариулсан. Харин үлдсэн 12% нь эрэлт хэрэгцээ байхгүй болон мэдэхгүй гэж хариулжээ. Эдгээрээс нэг сонирхолтой үр дүн ажиглагдсан нь NVivo программ эрэлт хэрэгцээтэй юу? гэсэн асуултад бакалаврын оюутнууд ихэвчлэн “үгүй”, “мэдэхгүй” гэж хариулт өгсөн байхад магистрантур болон докторантурт суралцагчид ерөнхийдөө “тийм” гэж хариулсан (Хүснэгт 3). Энэ нь судалгаа хийх эрэлт хэрэгцээ болон сургалтын түвшнээс хамааралтай буюу бакалаврын оюутнууд судалгаа шинжилгээний ажлыг харьцангуй цөөн хийдэг, харин магистрантур болон докторантурт суралцагчид диплом болон диссертацийн ажил зэрэг зайлшгүй хэрэгцээ шаардлагатай холбоотойгоор тайлбарлагдана.

**Хүснэгт 4**

NVivo программыг сургалтад нэвтрүүлбэл суралцагчдын сонирхол ямар байгаа эсэх

	Тийм	Үгүй	Мэдэхгүй	Нийт
Бакалавр	189	8	9	206
Магистрантур	27	0	0	27
Докторантур	27	0	0	27
Нийт	243	8	9	260

Энэ тохиолдолд Хүснэгт 3-тай харьцуулахад бакалаврын оюутнуудын “тийм” гэсэн хариултын тоо өссөн нь ажиглагдсан. Тодруулбал, хэрэв бакалаврын сургалтад NVivo программыг нэвтрүүлбэл оюутнуудын сонирхол их байгаа нь харагдаж байна. Харин магистрантур болон докторантурт суралцагчид NVivo программыг ашиглаж сурахыг эрмэлздэг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна (Хүснэгт 4).

**Хүснэгт 5**

NVivo программыг сургалтад нэвтрүүлбэл суралцагчдад хэр чухал байгаа эсэх

	Маш чухал	Чухал	Чухал биш	Мэдэхгүй	Нийт
Бакалавр	68	119	1	18	206
Магистрантур	9	18	0	0	27
Докторантур	17	10	0	0	27
Нийт	94	147	1	18	260

Хүснэгт 5-д гурван ялгаатай түвшинд суралцагчдын ойролцоогоор 36% нь маш чухал, 57% нь чухал, 7% нь мэдэхгүй гэж хариулсан байна. Мөн чанарын мэдээллийн шинжилгээний NVivo программыг сургалтад нэвтрүүлбэл хэр чухал вэ? гэсэн асуултад зарим бакалаврын оюутнууд “мэдэхгүй” гэж хариулсан нь тэдний судалгааны мэдлэг, туршлага, сургалтын түвшин

зэргээс хамааралтай байж болох юм.

**Зураг 1**

Суралцагчдын судалгаанд ихэвчлэн ашигладаг аргууд



Дээрх зурагт ярилцлага, ажиглалт, баримтын шинжилгээний аргуудыг чанарын мэдээлэл цуглуулахад судалгаанд оролцогчдын 60-70 хувь нь ашигладаг байна. Харин 30-40 хувь нь асуулгын аргыг тоон мэдээлэл цуглуулахад ашигладаг байна. Ингэснээр суралцагчид чанарын мэдээлэлд шинжилгээ хийхийн тулд NVivo программын ашиглах зайлшгүй шаардлагатайг харуулж байна.

**Дүгнэлт**

Монголын боловсролын салбарт чанарын судлаачдын тоо тасралтгүй өсөн нэмэгдэж байгаа нь чанарын судалгааны NVivo программын эрэлт хэрэгцээг нэмэгдүүлэх хандлагатай байна. Бодит байдалд тус программыг цөөн тооны судлаачид судалгааны баримт мэдээлэлд шинжилгээ хийхийн тулд ашиглаж байгаа хэдий ч дийлэнх нь ашиглаж чадахгүй байна. Тиймээс боловсролын салбарын төлөөлөл болсон МУБИС-ийн гурван түвшний суралцагчдад NVivo программын эрэлт хэрэгцээ хэр байгааг судалж дараах дүгнэлтэд хүрсэн.

Тус судалгааны түүвэрлэлтэд МУБИС-ийн 18-45 насны бакалаврын 206, магистрантурын 27, докторантурын 27 суралцагч тус тус хамрагдсан. Судалгаанд зарим бакалаврын оюутнууд NVivo программыг ирээдүйд суралцахыг илүүд үзсэн нь тэд судалгааны арга зүйд эхлэн суралцагчид гэдгээр тайлбарлагдана. Харин магистрантур болон докторантурт суралцагчид судалгааны ажилд тус программыг бүрэн дүүрэн ашиглаж сурахыг эрмэлзэж байгаа нь тэдний судалгааны сонирхол болон ахисан түвшинд судалгаа хийж байгаагаар холбоотой юм.

Судалгааны үр дүнд дийлэнх суралцагчид чанарын судалгааны мэдээлэл цуглуулахдаа ярилцлага, ажиглалт болон баримтын шинжилгээний аргуудыг ашигладаг бол бусад нь тоон мэдээлэл цуглуулахын тулд асуулгын аргыг ашигладаг байна. Тиймээс суралцагчид чанарын мэдээлэлд боловсруулалт хийж шинжлэхийн тулд

NVivo программыг ашиглах эрэлт хэрэгцээ байна гэж үзлээ.

#### Ашигласан материал

Батболд, Т., Ариунаа, Д., Баярмаа, Б., Батцэцэг, С., Зол-Эрдэнэ, Д. (2017). Судалгааны арга зүй. Улаанбаатар: Соёмбо Принт.

Батболд, Т., Ариунаа, Д., Баярмаа, Б., Батцэцэг, С., Зол-Эрдэнэ, Д. (2018). Судалгааны ажлын арга зүй. Улаанбаатар: Соёмбо Принт.

БСШУС-ын яам. (2017). 2016-2017 оны боловсролын салбарын статистикийн тайлан. Улаанбаатар.

Үндэсний статистикийн хороо. (2016). Статистикийн эмхэтгэл. Улаанбаатар.

Bengt, M. E., Allan, G. M. (2015). Nvivo 11 Essentials. Stockholm: Kunsclub.

Jones, M. L. (2007). Using Software to Analyse Qualitative Data. Journal of Qualitative Research, 1(1), 64-76.

Noriah, M. I., Abu, Y. B. (2012). Qualitative data management and analysis using NVivo: An approach used to examine leadership qualities among student leaders. Education Research Journal, Vol 2(3), 94-103.

QSR International Pty Ltd. (2016). Nvivo 11 Getting Started Guide. QSR International Pty Ltd.

### Demand and use of qualitative data analysis NVivo software

*T. Batbold*

*MNUE, School of Educational Studies,  
Research Methodology Department,*

#### Abstract

This research aims to define the need of NVivo software that has been newly practiced for qualitative data analysis in the educational sector in Mongolia over the last few years. The data was collected from totally 260 students - 207 BA, 27 MA., and the rest are doctoral students of Mongolian National University of Education (MNUE). The research methods were used data analysis in quantitative. The research finding shows that about 90-95 percent of students want to use the NVivo software and there is an urgent need, but what particularly interesting is that some bachelor's students generally answered 'No or Don't know' for the question regarding to the need and use of NVivo software. Also, it indicates that nearly 60-70 percent of students use the following methods for their research data, such as interview, observation and content analysis, and they could not effectively interpret their results, therefore, there is a great demand of using any qualitative softwares.

#### Keywords

Use, educational branch, qualitative data, learner, learning and MNUE